

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нямжанцан	Дугаар	L224
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Хутаг-Өндөр сумын Хантай баг
Төрсөн газар	Хутаг-Өндөр сум	Төрсөн он	1947
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гачой ламын хийд	Сүм хийдийн дугаар	БУХУ 021
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ц.Мөнхбат

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бургастын хийд буюу Гачой ламын хийд

Мөнхбат: Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багт Бургастын хатагчин энгэр гэдэг энэ газар байрлаж байсан буддын шашны энэ хурал номын газар энэ хүрээ хийдийн тухай ярилцахаар Хантай багийн иргэн 60 гаруй настай Нямжанцан гуайтай уулзаж байна. Энэ хүнтэй уулзаж байгаа зорилго нь энэ хүний аавынх нь төрсөн ах гавж хүн байсан. Энэ гавж хүн 1860 аад онд дунд үеэр төрөөд Булган аймгийн төв, тухайн үеийн Дайчин вангийн хошууны вангийн хүрээнд шавилан суугаад 20 насыг хүрээд 1880 оны дун үеэр нутагтаа ирсэн. Нутагтаа ирэхдээ Гачин лам гэж Төвд хүнтэй ирээд өөрийн орон нутагт бидний өнөөдөр судлаж буй Бургастай хүрээг анх байгуулсан. Тэргүүнээр нь Гачин лам өөрөө байсан. Гачин ламын нутаг буцсаны дараа Нямжанцан гуайн авга гавж Галсанжамц орон хийддээ толгойлон үлджээ. Ренчин гуайн жагсаалтанд байгаа энэ хийд дараах 3 нэрээр орсон бадаг 1-рт Хатагчин хийд, 2-рт Ачаа ламын хийд 3-т нь Гавж ламын хийд гэж орсон байдаг.. Ачаа гэдэг бол Гачин ламын нэрийг ташаарч бичсэн бололтой. Хатагч гэдэг бол Бургастай голын эхэнд байдаг Хатагчин энгэр гэж ингэж нэрлэж, Гавж ламын гэдэг бол бидний таамаглаж байгаагаар Гачин ламыг нутаг буцахад хийддээ үлдсэн гавж Галсанжамц гэдэг хүний цолоор нэрлэж байсан юм болов уу гэж таамаглаж байна. Та бидэнд авга ахынхаа тухай товч ярьж өгнө үү.

Нямжанцан: Галсанжамц гэдэг хүн Цэвэг тайж гэдэг хүний том хүү нь юм гэнэ лээ. Дороо 8, 9 чиг дүүтэй олуулаа. Гавж лам гачаа ламаас хойш хийдийг толгойлож сууж байгаад баривчилгааны үед баригдаад явсан юм гэнэ.

Мөнхбат: Хэр багадаа Ханатай нутгаас гарч вангийн хүрээрүү ном үзэхээр гарсан юм бол, хэдэн настай эргэж ирсэн юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нямжанцан: Манай аав ярихдаа 11, 12 той байсан юмдаг Хүрээ рүү ном үзэх гээд тэгээд 20 орчим настай эргэж ирсэн юм болов уу.

Мөнхбат:Тэгэхдээ төвдийн Гачин ламтай ирсэн юм болов уу?

Нямжанцан:Тэгсэн юм гэнэ лээ.

Мөнхбат: Тэгээд ирээд Гачин лам нь ирээд Бургастай хийдийг үүсгэн байгуулсан уу?

Нямжанцан:Аан, тийм үүсгэн байгуулсан.

Мөнхбат:Тэгээд Төвд ламтайгаа энд цуг сууж байсан. Төвд лам хэр удаж байж буцсан юм бол?

Нямжанцан:Ер нь нэлээд удсан юмдаг шүү. Манай аавын нэг дүүг өргөж авсан юм гэнэлээ. Галсан гавж олон дүүтэй хамгийн бага дүүг, эгчээс нь гарсан хүү байсан юм шиг байгаа юм тэр. Гачин ламын Дамбажамц гэдэг хүнийг өргөж авч элдэв ажилдаа түслүүлж байсан. Тэгээд Гачин ламын Дамбажамц Булганы хойд хэдэн сум андахгүй.

Мөнхбат:Тэгээд буцахад нь Бургастийн хийдийг авч явах хувь тохиожээ?

Нямжанцан:Тэгсэн юм шиг байгаа юм.

Мөнхбат:За лам буцаж. Галсанжамц гавж хийдийг тэргүүлж үлдээд хэр удаж байж их баривчилгаа болсон бэ?

Нямжанцан:Олон жил болсон шүү. Багшийгаа явчихлаар өөрөө толгойлоод үлдсэн 20,30-аад жил болсон дог шүү.

Мөнхбат:37,38 оны үед баригдаад явсан. Ямар сураг чимээ байсан юм бол?

Нямжанцан:Бид шүүлэгсэн Улсын архивт, баригдаж очоод сарын дараа цаазлуулсан юм уу. Манай эгч хотод байдаг юм тэрүүгээр үзүүлж харуулаад. Хаана яаж үхсэн юм бол гэж сураг гаргаач гэж. Тодорхой байна гэнэ лээ

Мөнхбат:Энэ хавийн лам нарыг хааш нь аваачиж яаж байсан юм бол? Булганы Вангийн хүрээ рүү юм болов уу, Архангай таруу юу?

Нямжанцан:Үгүй ээ, энэ чинь Сэлэнгэ аймгийн харъяа байсан юм Ханатын сум гэдэг чинь, тэгээд Сэлэнгэ рүү ачиж Алтанбулагт аваачиж байсан. Заримыг нь ч гайгүй гэснийгээ Хар далай манайд ажил хийлгэж байгаад хэдэн жил. Ажил хийж байгаад ирсэн хүн ч бий. Одоо бий лам хүн Тэшгийн хүн дээ Цэрэн гавж гэж хүн ирээд манай аавтай уулзаж байхыг би мэдэх юм. Галсан гавжъяй цуг баригдаад явсан юм. Галсан гавжийг яасныг нь мэдээгүй ээ, би ямар ч гэсэн Хар далайд ажил хийж. Тэр Хар далай нь хаа ч байдгийг би мэдэхгүй, Хар далай л гэж ярьж байгаа юм тэнд ажил хийж байгаад ирлээ гэж аавтай ярьж айраг ууж байсан.

Мөнхбат:Цагаатгагдах ажилд орсон. Булган 1997, 1998 онд Булганы Цагаан Ном гэж гаргасан аймагсумдаар тэр үед авч явсан улсуудынхаа нэр устай ном гарсан. Тэнд нэрс байж байдаг тиймээ?

Нямжанцан:Тийм.

Мөнхбат:Бургастай хийдийн гол шүтээн сахиус нь юу байсан юм бол? Ямар ном голчлон хурдаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нямжанцан: Би одоо сайн мэдэхгүй юм. Хүрээний хойд талын уулыг Дүнжингарав гэдэг, тэр уулаа жил бүр тахидаг тийм л ард түмэн байсан юм гэнэ лээ. Би тэр овоон дээр нь очиж үзсэн тэр бандан мандан гэдэг овоо нь сүртэй л юм байна лээ. Их л том юм хийж байсан болтой юм билээ. Тэр ном момын талаар би мэдэхгүй юм.

Мөнхбат: Жишээ энэ Архангай амгийн хойд сумд Сайн ноён хан аймгийн Далай шонхор вангийн хошуу тэр чигээрээ Вандан лам бурханыг шүтдэг байх жишээтэй. Айл өрх нь хошуу нутгийн сүм хийд нь тэр чигээрээ за ингээд урагшлаад Өлзийт сүм буюу, Өөлд бэйсийн хошуу нь Алтан зуу гэдэг бурханыг хошуу нутгаараа тахидаг байх, зарим газар нт Говийн Лха ч гэдэг юм уу, харин энэ Бургастай хийдийн энэ бүс нутгийн айл өрхүүд ямар бурхан тахидаг вэ?

Нямжанцан: Үгүй энэ чинь багад айлд ороход чинь одоо л бодож байхнээ дандаа нэг л тийм бурхангууд байдаг байсан. Юу гэж нэрлэдэг юм би харвал хэлчихээр л юм, бүгд нэг ижил цаасан бурхан гүүнд байдаг байсан.

Мөнхбат: Бургастай хийдэд бусад хийдэд явагддаг байсан шиг Цам харайх, Майдар эргэх ч гэдэг юм уу тийм зан үйл явж байсан юм бол уу? Тэр талаар санаанд үлдсэн юмаа ярина уу?

Нямжанцан: Би аав, ээж хоёроосоо дуулсан л юмаа ярихаас би үзсэн юм байхгүй л дээ. Цам харайна гэж ирээд л яридаг байсан. Тэр чинь одоо л тэр Цам юм байна лдаа.

Мөнхбат: Жас сангийн хувьд ямархуу жас сантай хүрээ хийд байв?

Нямжанцан: Хөрөнгө сайтай байсан гэнэ лээ. Энд тэндгүй л айлын бүүц байсан. Энэ жасын мал хариулж байсан айл гэж аав маань ярьдаг байсан. Бодоод байхад ер нь их олон газар тэр жасын мал байсан шиг байгаа юм. Энэ хийдийн л мал байж таараа тэр, жасын мал л гэдэг байсан. Жасын шар хариулдаг айл нэг, үнээг нь хариулдаг айл нэг гээд тийм өөр өөр байсан шиг байгаа юм. Энэ жасын шар хариулж байсан айл, тэдний бүүц гээд л ярьдаг байсан юм. Жалгат байгаа бүүцыг.

Мөнхбат: Ханатай сумын газар нутгийн дундуур Эгийн гол баруун хойноосоо орж ирээд үрсч байнаа. Ханатай суманд бүртгэлтэй байгаа буддын шашны 7 сүм хийдийн 3 голынхоо урд талд байна. Замбуу гийн хийд, 2 дахь Бургастай хийд, тэгээд Дэлгэр нугын хийд, Хойно бас 4 хийд байгаа. Эгийн гол дагасан энэ зурвас нутагт Өэлэнгэ сумын наад бие хүртэл, зөвхөн нэг суманд одоогоор бол нэг багт өөрөөр хэлбэл Хутаг-Өндөр сумын Ханатай баг 7 том хурал ном байсныг юу гэж бодож байна? Зарим газар нэг, хоёр л байдаг. Энэ ер нь юутай холбоотой юм бол?

Нямжанцан: Нэг голынхон гэхэд л жишээ нь манай Хатагчин энгэр чинь голоороо яриад явбал 7,8, арваад гол бий, айлууд жилийн дөрвөн улиралд хаваржиж, зусч, намаржиж, өвөлжиж байдаг ийм нутаг юм. Олон түмнийхээ гол дунд байгуулж байсан юм биш үү. Жишээ нь эндээс нэг морьтой хүн ном уншуулах гээд Эг гаталж явах төвөг байна шүү дээ. Тэгэхлээр олон айлыг түшиглээд л дуганаа байгуулж байсан болов уу гэж бодож байна.

Мөнхбат: Цагийн хурал гэж, хавар нэг ойролцоох том хийдээс хэдэн лам нар ирж 7,8 хоног ном хурдаг, намар нэг хурдаг, бусал үед нь тахилч лам нт үлдээд бурханых нт тоосыг арчаад зул өргөөд байж байдаг. Гэтэл энэ Ханатай сумынх болохоор байнгын хуралтай, тогтмол лам нар суудаг хийдүүд байжээ, 5,6 дуганатай ихэвчлэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Магадгүй Булган аймгийн хойд талын сумууд, Хөвсгөл аймгийн Цагаан Үүр, Булган аймгийн Тэшиг сум хойд хийл дагасан харуулуудаас урагшаагаа бүс нутгийн шарын шашны томоохон бүс нутаг байсан юм болов уу гэдэг таамаглал төрж байна.

Нямжанцан:Тэр үнэн юм шиг байгаа юм.